



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙДАЛ**

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2019/02



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд
- IV. Гэмт хэрэг
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал




I. Нийгмийн байдал

I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 188, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 136 байгаагийн 60 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 188 буюу 2.0 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Хоёрдугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 98 ажлын байрны захиалга ирж, 69 иргэн үүнээс 34 эмэгтэй ажилд зуучлагдсан байна.

Зураг I.1. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст



Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 31, 25-34 насны 52, 35-44 насны 27, 45-54 насны 21, 55 түүнээс дээш насны 5 иргэн байна.


I.2 Ердийн хөдөлгөөн

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2019 оны эхний 2 сарын байдлаар 67 эх амаржиж, 67 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх болон төрсөн хүүхдийн тоо 9 буюу 11.8 хувиар, буурсан байна.

Нас баралт 10, бүртгүүлсэн гэр бүл 11, цуцалсан гэр бүл 5 байгаа нь өмнөх оны мөн үеэс нас баралт 5 буюу 33.3 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 3 буюу 21.4 хувиар буурч, цуцалсан гэр бүл 3 буюу 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд үрчлэгдсэн хүүхэд 1 байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна. Шилжилт хөдөлгөөний мэдээгээр 33 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт 3.5 дахин буурчээ.



Зураг I.2. Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 2 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

2019 оны эхний 2 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 1750.8 сая төгрөг, зарлага 1817.0 сая төгрөг болсон байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 163.7 хувьтай, зарлагын гүйцэтгэл 96.4 хувьтай байна.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2019 оны эхний 2 сарын байдлаар 3680 хүнд 445.3 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 508 хүн буюу 16.0 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 67.8 сая төгрөг буюу 17.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2019 оны эхний 2 сарын байдлаар 1526 хүн хамруулж 197.3 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 223 хүн буюу 17.1 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 39.1 сая төгрөг буюу 24.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2019 оны эхний 2 сарын байдлаар 2154 хүн хамруулж 247.9 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 285 хүн буюу 15.2 хувь, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 28.7 сая төгрөг буюу 13.1 хувь өссөн үзүүлэлттэй байна.


II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны 2 дугаар сарын мэдээгээр 189 байгууллагын 4361 даатгуулагч иргэн, үүнээс 346 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 319 даатгуулагчийн дундаж цалин 962.3 мянган төгрөг, төсөвт 53 байгууллагын 1457 даатгуулагчийн дундаж цалин 865.1 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 570 даатгуулагчийн дундаж цалин



1601.6 мянган төгрөг, 107 ХХКомпаний 1573 даатгуулагчийн дундаж цалин 1127.5 мянган төгрөг, бусад 16 аж ахуйн нэгж байгууллагын 96 даатгуулагчийн дундаж цалин 602.7 мянган төгрөг боллоо.

Зураг II.1. Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2019 оны 2 сарын байдлаар




III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2019 оны эхний 2 сарын байдлаар 67 эх амаржиж, 2018 оны мөн үетэй харьцуулахад 15 буюу 18.3 хувиар буурсан байна. Амьд төрсөн хүүхэд 67 үүнээс 36 нь хүү, 31 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс төрсөн хүүхдийн тоо 15 буюу 18.3 хувиар буурсан байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 гарч, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл болон эхийн эндэгдэл гараагүй.


Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



Халдварт өвчин тайлант сарын байдлаар 10000 хүн амд 16.6 буюу өмнөх оны мөн үеэс 6.8 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.



Зураг III.2.Нас баралт, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 17351 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 821 хүнээр буюу 5.0 хувиар, 874 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 87 хүнээр буюу 11.1 хувиар өссөн байна.

2019 оны эхний 2 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 1237, халдварт өвчин 29 бүртгэгдсэн байна.


Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхсын эндэгдэл, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2019 оны эхний 2 сарын байдлаар 32 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1 буюу 3.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 2 сарын байдлаар






Илрээгүй гэмт хэрэг 22 байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 26.7 болсон нь өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 17 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 41.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Зураг IV.2. Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 2 сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2019 оны эхний 2 сарын байдлаар 27.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 3.7 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 4.2 дахин, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 3.8 дахин буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны эхний 2 сарын байдлаар давхардсан тоогоор 136 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 51 хүнээр буюу 60.0 хувиар өссөн байна.

Зураг IV.3. Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн эхний 2 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2019 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар, 2018 оны жилийн эцсээс 0.4 хувиар, өмнөх сараас 0.3 хувиар тус тус өссөн байна.



Хүснэгт V.1.Хэрэглээний үнийн индекс, 2019 оны 2 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2019.II}{2018.II}$	$\frac{2019.II}{2018.XII}$	$\frac{2019.II}{2019.I}$
Ерөнхий индекс	104.6	100.4	100.3
Хүнсний бараа, ундаа, ус	107.7	103.7	100.7
Согтууруулах ундаа, тамхи	110.7	103.1	102.5
Хувцас, бөс бараа, гутал	100.9	100.0	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	103.8	100.1	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	108.2	100.4	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	100.8	100.2	100.0
Тээвэр	102.1	96.0	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	101.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	120.0	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	110.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	106.9	100.2	100.0

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ


**VI. Төсөв санхүү**

2019 оны эхний 2 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2358.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 2188.8 сая төгрөг болж 92.8 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 3804.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 2108.3 сая төгрөг болж 55.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

2019 оны 2 сарын байдлаар авлагын үлдэгдэл 26.6 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 68.3 сая төгрөг байна.

Зураг VI.1.Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 2 сарын байдлаар , сая төгрөгөөр







VII. Мал аж ахуй

2019 оны төллөх насны 203579 хээлтэгч малаас эхний 2 сард 222 мал буюу төллөх насний хээлтэгчийн 0.1 хувь нь төллөсөнөөр өмнөх оны мөн үеийнхээс 63.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2019 оны эхний 2 сарын байдлаар 17 толгой том мал зүй бусаар хорогдсон байна. Өмнөх оны мөн үед том малын хорогдол 6012 байсан болно.

Зураг VII.1.Төллөсөн хээлтэгч, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, толгойгоор



Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, толгойгоор



VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2019 оны эхний 2 сарын байдлаар 10753.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1187.5 сая төгрөг буюу 12.4 хувиар, оны үнээр 12087.0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1396.9 сая төгрөг буюу 13.1 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нь нийт бүтээгдэхүүний 88.3 хувь буюу 9489.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 94.7 хувь буюу 11444.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.



Зураг VIII.1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, сая төгрөгөөр



III. Өнгөрсөн сарын цаг агаарын тойм мэдээ



Хур тундас: 8-ны өдрүүдэд цас орж, нийт 0,0 мм тунадастай.

Салхи: Энэ сард ихэнхи хугацаанд салхи 4-9 м/сек, 2-ны өдөр 13-15 м/сек хүрч ширүүссэн.

Агаарын температур: Агаарын температур 1-р аравт шөнөдөө 29-34 градус хүйтэн, өдөртөө 8-13 градус хүйтэн, 2-р аравт шөнөдөө 26-31 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус хүйтэн, 3-р арав хоногт шөнөдөө 13-18 градус хүйтэн, өдөртөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан байсан байна.

ГУРАВДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Энэ сард агаарын дундаж температур манай аймгийн нутгаар 5-10 градус байдаг ба уур амьсгалын дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байна. Нэгдүгээр арав хоногийн сүүлчээр, хоёрдугаар арав хоногийн эхээр бага зэрэг хүйтэрч шөнөдөө 13-18 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан байна. Нэгдүгээр арав хоногийн эхээр, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр хүйтний эрч суларч шөнөдөө 7-12 градус хүйтэн, өдөртөө 7-12 градус дулаан байна. Гуравдугаар арав хоногт нийт нутгаар дулаарч шөнөдөө 2-7 градус хүйтэн, өдөртөө 13-18 градус дулаан байна. Энэ сард уур амьсгалын дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн сүүлчээр, хоёрдугаар арав хоногийн эхээр, сүүлчээр зарим газраар бага зэргийн цас, гуравдугаар арав хоногийн дунд үеэр хур тунадас орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн сүүлчээр болон хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар 12-14 м/с, хоёр болон гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар 16-18 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.





ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	82	67	81.7
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	175	136	77.7
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	39	29	74.4
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	33	32	97.0
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	2262.1	2188.8	96.8
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	2273.3	2108.3	92.7
Авлага	сая.төг	17.3	26.6	153.8
Өглөг	сая.төг	49.9	68.3	136.9
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	9565.8	10753.3	112.4
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	10690.2	12087.1	113.1
Төллөсөн хээлтэгч	толгой	605	222	36.7
Гарсан төл	толгой	606	222	36.6
Хорогдсон төл	толгой	96	0	*
Бойжсон төл	толгой	510	222	43.5
Том малын зүй бусын хорогдол	толгой	6012	17	0.3



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	376	188	50.0
Үүнээс: эмэгтэй	233	86	36.9
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	175	136	77.7
Үүнээс: эмэгтэй	102	60	58.8
Ажлын байрны захиалга	3	98	5 227.4
Ажилд зуучлагдсан иргэд	0	55	*
Үүнээс: эмэгтэй	0	29	*

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Амаржсан эх	76	67	88.2
Төрсөн хүүхэд	76	67	88.2
Үрчлэгдсэн хүүхэд	1	1	100.0
Бүртгүүлсэн гэр бүл	14	11	78.6
Цуцалсан гэр бүл	2	5	250.0
Нас баралт	15	10	66.6
Шилжин ирсэн	118	33	28.0

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сангийн төрөл	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
НД-ын сангийн орлого, сая.төг	1 310.7	1 750.8	133.6
НД-ын сангийн зарлага, сая.төг	1 952.6	1 817.0	93.1

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 II		2019 II		$\frac{2019 II}{2018 II} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	3 172	377.5	3 680	445.3	116.0	117.9
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1 303	158.2	1 526	197.3	117.1	124.7
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	1 869	219.2	2 154	247.9	115.2	52.6

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 2 эхний сарын байдлаар

Үзүүлэлт	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Төрсөн эх	82	67	81.7
Амьд төрсөн хүүхэд	82	67	81.7
Эрэгтэй	32	36	112.5
Эмэгтэй	50	31	62.0
Амьгүй төрсөн хүүхэд	0	0	*
Нийт нас баралт	9	6	66.7
Эмнэлгийн нас баралт	3	2	66.7
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	2	*
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0	*
Амбулаторийн үзлэг	16 530	17 351	105.0
Халдварт өвчин	39	29	74.3

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ



IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	33	32	97.0
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	13	14	107.7
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	13	13	100.0
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	0	0	*
Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	2	1	50.0
Бусад гэмт хэрэг	0	4	*
Гэмт хэрэгт холбогдогсод	17	12	70.6
15 хүртэлх насны	0	0	*
16-34 насны	11	9	81.8
35 ба түүнээс дээш насны	6	3	50.0
Боловсрол – Дээд	1	1	100.0
Боловсрол - Тусгай дунд	1	0	*
Боловсрол – Бүрэн дунд	9	5	55.6
Боловсрол – Бүрэн бус дунд	4	4	100.0
Боловсрол – Бага	2	1	50.0
Боловсролгүй	0	1	*
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	4	6	150.0
Ажилгүй иргэд үйлдсэн	14	4	28.6
Эмэгтэй хүн оролцсон	4	1	25.0
Хүүхэд оролцсон	1	0	*
Бүлгээр үйлдсэн	1	3	300.0
Согтуугаар үйлдсэн	7	6	85.7
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	33	32	97.0
Гудамж талбай, олон нийтийн газар	7	10	142.9
<u>Гэмт хэргийн улмаас нас барсан</u>	1	1	100.0
<u>Гэмт хэргийн улмаас гэмтсэн</u>	12	17	141.7
Учирсан хохирол / сая.төг /	115.0	27.0	23.5
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	14.0	3.7	26.4

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ



VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Нийт орлого	2 262.1	2 188.8	96.8
Урсгал орлого	772.6	630.4	81.6
Татварын орлого	610.8	557.9	91.3
Татварын бус орлого	161.9	72.5	44.8
Тусламжийн орлого	1 489.4	1 558.4	104.6

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Нийт зарлага	2 273.3	2 108.3	92.7
Урсгал зардал	2 059.9	2 100.6	102.0
Хөрөнгийн зардал	213.4	7.7	3.6

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Авлага	17.3	26.6	153.8
Өглөг	49.9	68.3	136.9
Төсөвт байгууллагын тоо	49	48	98.0
Төсөвт байгууллагын ажиллагсад	783	783	100.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ



II.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Бүгд	605	222	36.7
Ингэ	0	0	*
Гүү	2	0	*
Үнээ	53	9	17.0
Эм хонь	368	154	41.8
Эм ямаа	182	59	32.4

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сумд	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Дүн	605	222	36.7
<u>Баянтал</u>	165	90	54.5
Сүмбэр	370	101	27.3
<u>Шивээговь</u>	70	31	44.3

VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Бүгд	510	222	43.5
Ботго	0	0	*
Унага	2	0	*
Тугал	47	9	19.1
Хурга	318	154	48.4
Ишиг	143	59	41.3

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сумд	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Дүн	510	222	43.5
<u>Баянтал</u>	129	90	69.8
Сүмбэр	317	101	31.9
<u>Шивээговь</u>	64	31	48.3



VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Бүгд	6 012	17	0.3
Тэмээ	0	0	*
Адуу	297	0	*
Үхэр	422	13	3.1
Хонь	1 847	4	0.2
Ямаа	3 446	0	*

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сумд	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Дүн	6 012	17	0.3
<u>Баянтал</u>	639	6	0.9
Сүмбэр	5 109	11	0.2
<u>Шивээговь</u>	264	0	*

VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Төрөл	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Бүгд	1 196	8	0.7
Тэмээ	0	0	*
Адуу	77	0	*
Үхэр	117	0	*
Хонь	594	4	0.7
Ямаа	408	4	1.0

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Сумд	2018 II	2019 II	$\frac{2019 II}{2018 II} \%$
Дүн	1 196	8	0.7
<u>Баянтал</u>	128	6	4.7
Сүмбэр	1005	2	0.2
<u>Шивээговь</u>	63	0	*



VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 II	2019 II	$\frac{2019 \text{ II}}{2018 \text{ II}}\%$
Нийт	9 565.8	10 753.3	112.4
Уул уурхай, оллборлох аж үйлдвэр	8 929.7	9 489.9	106.3
Боловсруулах аж үйлдвэр	22.4	160.2	715.3
Цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	613.7	1 103.2	179.8

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 2 сарын байдлаар , сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 II	2019 II	$\frac{2019 \text{ II}}{2018 \text{ II}}\%$
Нийт	10 690.2	12 087.0	113.1
Уул уурхай, оллборлох аж үйлдвэр	10 044.2	11 444.8	113.9
Боловсруулах аж үйлдвэр	31.2	22.5	72.1
Цахилгаан, дулаан эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	614.8	619.8	100.8

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 2 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 II	2019 II	$\frac{2019 \text{ II}}{2018 \text{ II}}\%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	10 044.2	11 444.8	113.9
Нүүрс олборлолт /үнийн дүнгээр, сая.төг/	8 929.7	9 489.9	106.3
Ажиллагсад	541	546	100.9

Е-майл хаяг:

Вэб хаяг:

Мэдээллийн сангийн хаяг:

Утас:

govisumber@nso.mn

govisumber.nso.mn

www.1212.mn

70543222, 70543017